



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 5/11

Хэрлэн сум

Ажилд томилох, чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 26 дугаар зүйлийн 26.3, Улсын Их Хурлын 2007 оны "Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоолын 1, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.3 дахь заалт, Засгийн газрын 2014 оны "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" 333 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Багийн Иргэдийн Нийтийн Хурлын анхдугаар хуралдаанд оролцсон иргэдийн олонхын санал авсан, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5, 26.5.1, 26.5.2, 26.5.3, 26.5.4, 26.5.5 дахь заалтад заасан шаардлагыг хангасан Чадраабалын Чинбатыг Бэрх хотын Захирагчаар 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс томилсугай.

Хоёр. Бэрх хотын захирагчийн үндсэн цалинг 720257 /долоон зуун хорин мянга хоёр зуун тавин долоон/ төгрөгөөр тогтоож, улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын цалингийн 30 хувиар тооцож цалинжуулахыг Бэрх хотын Захирагчийн ажлын албаны дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон Бэрх хотын захирагч Х.Баасанжавыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, ажилласан хугацааны тооцоог хийж, 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгохыг Бэрх хотын захирагчийн ажлын албаны дарга, нягтлан бодогч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА